



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 470

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд өөрчлөлт
оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар 62.1.1, 62.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2019 онд хийгдсэн нийт 284,376,670 (хоёр зуун наян дөрвөн сая гурван зуун далан зургаан мянга зургаан зуун далан) төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийн дүнгээр “Баянчандмань АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн эзэмшигчийн өмч дэх төрийн өмчийн дүнг нэмэгдүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. “Баянчандмань АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 3.1-д “Компанийн зарласан хувьцаа нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 6,616,272.3 (зургаан сая зургаан зуун арван зургаан мянга хоёр зуун далан хоёр) ширхэг энгийн хувьцаатай гэснийг “ нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 9,460,039.0 (есөн сая дөрвөн зуун жаран мянга гучин есөн) ширхэг энгийн хувьцаатай” гэж өөрчлөн найруулсугай.

3. “Баянчандмань АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 3.1-д төрийн өмчит хувьцаат компанийн эзэмшигчийн өмчийн өмч дэх төрийн өмчийн дүнд орсон өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэхийг компанийн Ерөнхий инженер бөгөөд гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхбаярт үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ